



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 01

Ховд

**Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг
дээшлүүлэх тухай**

Төрийн албаны шинэ хууль, түүний хүрээнд батлагдсан журмуудын хэрэгжилтийг хангах, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмжийг дээшлүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а" заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмжийг дээшлүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах чиглэлд дараах арга хэмжээнүүдийг үр дүнтэй, шуурхай зохион байгуулахыг сумдын Засаг дарга, албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарт даалгасугай. Үүнд:

1.1. "Орон нутгийн удирдах ажилтны улсын зөвлөгөөн"-д Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн өгсөн үүрэг, даалгаврыг өөрийн сум, байгууллагад хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган, улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдрийн дотор тогтмол тайлагнаж байх

1.2. Шинэчлэгдэн батлагдсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм"-ийг албан хаагч бүрт танилцуулан, судлуулж, байгууллагын ёс зүйн зөвлөлөө шинэчлэн байгуулж, Төрийн албаны нэр хүндийг өндөрт өргөж, бүх шатанд хууль, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллах

1.3. Төрийн албаны шинэ хуулийн хүрээнд батлагдсан холбогдох дүрэм, журмыг албан хаагчиддаа сурталчилж, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, сум, байгууллагынхаа хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах

2019 01/Ch
02 00002

1.4. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд сум, байгууллагадаа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмжийг дээшлүүлж, үйлчилгээг иргэддээ ойртуулах, аймгийн “Хариуцлагатай тунгалаг төр” хөтөлбөрийг иргэд, олон нийтэд сурталчлах, хэрэгжилтийг хангаж ажиллах

1.5. Өрхийн болон жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжиж жилийн хүрээнд “Үйлдвэрлэгч-Ховд” хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн бизнес эрхлэгчиддээ олон талт дэмжлэг үзүүлэн, ажлын байрыг бодитой нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх

Хоёр. Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүрэг, даалгавар, Төрийн албаны шинэ хууль, журам, шинэчлэлийн бичиг баримтуудыг сум, байгууллага бүрт хүргэж, албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийн явцын мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ